

Төлбөрийн тэнцэл хариуцсан мэргэжилтэн, Жамбалбавуу Өлзийсайхан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тодорхойлсон "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" зэрэг бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг үргэлжлүүлэх ба "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ	3-р сар, 4-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ"- ыг зорьж эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлнэ.		
1.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах;							
2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	-	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын 2036 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай импортын бараа бүтээгдэхүүний тоо мэдээлэл шинжилгээ хийж, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны төсөөллийг хийж, нэгдсэн макро эдийн засгийн танилцуулгыг нэгтгэн боловсруулсан. Уг төсөөллийн боловсруулах хүрээнд уул уурхайн томоохон аж ахуй нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, төсөөлөл хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулсан. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 12.1 хувиар өссөн бол гадаад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Өрхийн орлого сайжирч, хэрэглээний зээл нэмэгдсэн нь хэрэглээний бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын автомашины импортыг өдөөлөө. Тухайлбал, иргэдэд шинээр олгосон зээл 2024 онд 34 хувиар өсөж, суудлын автомашины импорт өмнөх оноос 67 хувиар өссөн байна. Суудлын автомашины импорт нэмэгдэж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээний тоо өссөнтэй холбоотойгоор авто бензиний импорт 643 сая ам.долларт хүрч, 23 хувиар өслөө. Хавсралт: 1 файл		
3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	2025 оны I, II улиралд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга/	Монгол Улсын эдийн засгийн 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улирлын гадаад худалдааны нөхцөл байдалд дүн шинжилгээ (Macro diagnostics) хийж, улирлын тайланг төлөвлөгөөт хугацаанд боловсруулан, яамны веб хуудсанд байрлуулж,	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					хэвлүүлэн холбогдох байгууллага, судлаачид, иргэдэд хүргүүлээд байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан хэдий ч худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс буурлаа. Монгол Улс 2025 оны эхний улирлын байдлаар дэлхийн 123 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 465 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 5.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буурлаа. 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байв. Харин 2025 оны эхний улирлын байдлаар импорт өмнөх оны мөн үеэс 134 сая ам.доллар буюу 5.5 хувиар өсөж, өсөлтийн хурд саараад байна. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	---	--	--

1.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох

4	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	2024 оны 1-6 сард танилцуулга бэлтгэсэн байна./6 танилцуулга/	2025 оны 1-ээс 6 дугаар сарын тоо мэдээлэлд сар бүр дүгнэлт хийж, сарийн мэдээний танилцуулга бэлдэж удирдлагуудыг мэдээллээр хангаж, яамны цахим хуудсанд байрлуулан, олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан. Хавсралт: 4 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
5	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.	Мэдээллийн тоо	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн	Тухай бүр мэдээллээр хангасан байна	Гадаад худалдааны голлох тоо мэдээлэл болох экспорт, импортын өдөр тутмын мэдээлэл, хилээр орсон болон гарсан машин, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ, гадаад валютын ханшийн мэдээллийг өдөр бүр нэгдсэн системд оруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Нийт экспорт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын долоо хонгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. Мөн уул уурхайн биржийн өмнөх өдрийн арилжаа, дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэл, болон зарим голлох бүтээгдэхүүний экспорт,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					импортын тоонд дүн шинжилгээ хийж, өдөр бүрийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан		
1.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх							
6	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	"Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2029 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2025.04.23-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 19 дүгээр тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг 2024.04.30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					холбоотойгоор Төсвийн байнгын хороо, Улсын Их хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхэд төсвийн тооцоолол, танилцууллагыг тухай бүр бэлтгэж, 2025 оны 5 дугаар сарын 30 ны өдөр батлуулсан. Уг хуулийн төслийг боловсруулах, болон Засгийн газар, Байнгын хороол, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай материалыг бэтэгтгэх, мэдээллээр хангах ажилд оролцож ажилласан. Хавсралт: 4 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	-	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Ажлын цагийг үр дүнтэй ашиглаж ажилласан бөгөөд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд ОУВС-ийн "Macroeconomic diagnostic" сургалтад хамрагдсан	6-р сар, 12-р сар	100%
2	Албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	-	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Л. Энх-амгалан /...../

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төлбөрийн тэнцэл хариуцсан мэргэжилтэн, Жамбалбавуу Өлзийсайхан /...../

Огноо: 6/25/2025

